



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 12 сарын 04 өдөр

Дугаар А/532

Мандалговь

Г

Газар эзэмших эрхийг
шилжүүлэх тухай

Г

Монгол улсын "Газрын тухай хууль"-ийн 30 дугаар зүйл 30.2, 38 дугаар зүйл 38.1, 38.4 дэх заалтууд, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3 дах заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

Нэг. Сайнцагаан сумын төвийн 7 дугаар багийн нутаг дэвсгэрт (Төрөх тасгийн зүүн хойно Худалдааны гудамж 2-210) байршилтай 144 м.кв (0,01га) орон сууцны зориулалттай газрыг эзэмшигч иргэн Бунъяа овогтой Батсайхан (ЦГ:69111958) нь 2018 оны 04 дүгээр сарын 21-ний өдөр нас барсан тул эхнэр Даваа овогтой Уранчимэг (ЗЕ:78022100)-т газрыг зориулалтаар шилжүүлж 22 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

Хоёр. Дээрх иргэнтэй газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгохыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Э.Чагнаадорж), мөн гэрээний биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг ГХБХБГазар, Сайнцагаан сумын Засаг дарга, хотын захирагч (Р.Мөнхтогтох), аймгийн Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат) нарт тус тус үүрэг болгосугай.

Гурав. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2010 оны 10 сарын 13-ны өдрийн А/460 тоот захирамжийн иргэн Б.Батсайхан-д холбогдох хэсэг мөн газар эзэмших 0300826 тоот гэрчилгээг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

438010649

